

ТОЛЬ АШИГЛАХ ЗААВАР

1. “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” нь “Уриалга” (iii-iv), “Уялга үг” (v-vi), ““Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг батлах тухай тогтоол” (vii), “Өмнөх үг” (ix-xiv), “Толь ашиглах заавар” (xv-xvi), “Товчилсон үг, тэмдэг” (xvii), “Толины үндсэн үг” (1-270, 292-487), “Монгол кирилл үсгийн дүрэм” (271-291), “Гадаад үг” (488-509), “Үг хувилгах жишээ” (510-520), “Аймаг, сум, дүүргийн нэр” (521-524), “Дипломат харилцаатай улс орны нэрс” (524-527), “Багцалсан дүрэм” (528-537), “Багцалсан үг” (538-539), “Ном зүй” (540-542) гэсэн хэсгээс бүрдэнэ. Энэ нь толийг ашиглах болон үгийг хэрхэн бичихийг хялбар олох зорилготой холбоотой ангилал юм.
2. Журамласан толийг зөв хэрэглэж сурахад эхлээд “Өмнөх үг”, “Толь ашиглах заавар”-ыг унших нь тустай. Мөн “Монгол үсгийн дүрэм”-ийн хэсгийг сайтар унших нь зөв бичих чадварыг эзэмшихэд тустай юм.
3. Толгой үгийг тод хөх өнгөөр ялган, үгийг үндсээр нь бичиж, үйл үгийг богино зураасаар (-) ялгасан болно.
4. Толгой үгийн хэрэглээг идэвхтэй (●●●), харьцангуй идэвхтэй (●●○), идэвхгүй (●○○) гэж ялган дугуйг улаан өнгөөр будаж тэмдэглэсэн нь үгийн утга, хэрэглээг эзэмших, сургалтад ашиглахад тустай юм.
5. Толгой үгийн нэр үгийг I, үйл үгийг II гэсэн ром тоогоор, арын 1.1, 1.2, 1.3 гэсэн араб тоогоор хэл зүйн хувиллын дүрмийг дугаарлаж заасан болно. Иймд үгийг хэл зүйн хувиллаар хэрхэн хувилгаж бичихийг сайн мэдэхгүй байгаа бол энэ дугаарыг ашиглан “Үг хувилгах жишээ” хэсгээс хараад яаж хувилган бичихийг мэдэж болно.
6. Толгой үгийн хэл зүйн ангиллыг Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад мөрдөж байгаа жинхэнэ нэр [ж.н], үйл үг [үй.ү], тэмдэг нэр [тэ.н], тооны нэр [то.н], төлөөний үг [тө.ү], орны нэр [о.н], цагийн нэр [ц.н], холбох үг [хо.ү], баймж үг, бүтээвэр [баймж], дүрс дуурайх үг [д.д.ү], авиа дуурайх үг [а.д.ү], аялга өгүүлбэр [а.ө], дутмаг үйл үг [дут.ү.ү] гэж дөрвөлжин хаалтад ялган товчилж тэмдэглэв. Энэ нь уг үгийн хэл зүйн үүргийг мэдэхэд тустай юм.
7. Ижил бичлэгтэй үгсийг тусгайлан дугаарлалгүй, хэл зүйн хувиллын үүргээр нь жинхэнэ нэр [ж.н], үйл үг [үй.ү] гэж ялгахын хамт, бусад ижил үгийг хэрэглээг нь анхаарч дараалуулсан болно.
8. Толгой үгийн гол утгыг ойлгохын тулд товч тайлбар дагалдууллаа. Хэрэв салаа утга илэрхийлж байгаа бол цэгтэй таслалаар (;) ялгав. Толгой үгийн утгыг холбоо үгээр тайлбарлахдаа толгой үг нь давтагдаж байгаа бол долгион зураасаар (~) ялгасан болно. Жишээ нь: **туш- ●●○** II.9.1 [үй.ү] морь ~; садаа болох, харшлах гэх мэт.
9. Гол төлөв холбоо үгээр хэрэглэгдэх толгой үгийн дараа тодорхойлох цэг (:), тавьж товч тайлбарыг дагалдуулсан болно. Жишээ нь: **тулгарт ●○○** [ж.н] ~ малгай: ёслолын малгай гэх мэт.
10. Ихэнхдээ нэр томъёоны үүрэгтэй амьтан, ургамлын нэрийн утгыг тодорхой болгохын үүднээс толгой үгийн ард амьтны нэрийг (амь.),

ургамлын нэрийг (урга.) гэх мэтээр нуман хаалтад тэмдэглэсэн болно. Жишээ нь: **голт** I.1.2 ●○○ (урга.) [ж.н] нэг зүйл бут, үр нь эмд орно гэх мэт.

11. Монголжсон гадаад үгийг монгол үгийн жагсаалтад оруулсан бол шинэ тутам монгол хэлэнд орсон гадаад үгийг гадаад үгийн жагсаалтад оруулж хэл зүйн хувиллыг нь бичсэн болно. Жишээ нь: **график** I.27.1 графикайн, графикт, графикайг, графикаас, графикаар, графиктай, график руу, графикаа гэх мэт.
12. Монголчлох бололцоо бүхий зарим гадаад үгийг гадаад үгийн жагсаалтад оруулалгүй орхисон тул тэдгээр үг хэллэгийг монголоор нэрлэж хэвших нь зөв юм. Жишээ нь: **факультет** (салбар сургууль) гэх мэт.
12. Энэ толь нь зөв бичих дүрмийн толь учраас үгийн утгад дэлгэрэнгүй тайлбар хийгээгүй бөгөөд зөвхөн уг үгийн товч утгыг толгой үгийн ард хадаж өгсөн болно.